



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит бус 01 дүгээр хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаан 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар /2025-02-13/ ЗГХЭГ-ын дарга, Монгол Улсын сайд, Зөвшөөрлийн зөвлөлийн хурлын (2025-02-06, ЗГ/395) зөвлөмж, ХЗДХ-ийн сайд (2025-02-07, 01/772)-ын албан тоот, ЦХИХХ-ны сайд 2025-02-12, 01/348)-ын албан тоотоор ирүүлсэн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор ажлын албаны бүтцийн нэгжээс боловсруулсан “Зөвшөөрлийн тухай болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслүүд, ХХЗХ-ноос баталсан Захиргааны хэм хэмжээний актын талаар авах зарим арга хэмжээний тухай” танилцуулга, ХХЗХ-ноос баталсан Захиргааны хэм хэмжээний актын дүн шинжилгээ, хэрэгжүүлэх арга хэмжээний санал, тогтоолын төслүүд, үүнийг даган Зөвшөөрлийн тухай болон холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт, өөрчлөлт, хүчингүй болгох хуулийн төслийн санал зэрэг баримт бичгүүдийг хэлэлцээд, зохицуулах хорооны 14 (Тогтоол №28-41, 2025-02-13) тогтоолыг батлан шийдвэрлэв.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь зөвшөөрлийн хүсэлт, материалыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэж байгаа бөгөөд Зөвшөөрлийн тухай хуульд хүсэлтийг 22 хоногт шийдвэрлэхээр заасныг тус хороо нь дунджаар 9,2 хоногт, зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг 8,4 хоногт тус тус багтаан шийдвэрлэн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын “Бизнест ээлтэй Монгол” хөтөлбөр болон Зөвшөөрлийн зөвлөлөөс 2025-02-06 өдөр ХХЗХ-ноос баталж, ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний актад бүртгэлтэй байгаа ч зөвшөөрлөөс давсан, цуцлах шаардлагатай гэж үзсэн нэр бүхий нөхцөл, шаардлага, журам, бусад зохицуулалтын баримт бичгийн жагсаалтыг олон нийтэд цахим сүлжээгээр мэдээлсэн болно. Улмаар Зөвшөөрлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр болж 01 тоот дүгнэлтийг баталсан бөгөөд уг дүгнэлтийн 1.2-т заасны дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцаа зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасаж, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотор холбогдох мэдээллийг ирүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд даалгасан юм. Түүнчлэн ЦХИХХ-ны сайд нараас ирүүлсэн албан тоотын дагуу холбогдох саналаа 2025-02-17 өдрийн дотор ирүүлэхийг ХХЗХ-нд үүрэг чиглэл болгосон. Эдгээр албан тоотоор өгөгдсөн санал зөвлөмж болон удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэн Зохицуулах хорооны 2025 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар дараах 14 тогтоол, шийдвэрийн баталсан болно. Үүнд:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны дараах тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгосон.
 - 1.1 “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журам батлах тухай” тус хорооны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 73 дугаар тогтоол;
 - 1.2 “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” батлах тухай тус хорооны 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 105 дугаар тогтоол;
 - 1.3 “Радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах” тухай тус хорооны 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 69 дүгээр тогтоол;
 - 1.4 “Цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх аргачлал батлах тухай” тус хорооны 2021 оны 12 дугаар 17-ны өдрийн 74 дүгээр тогтоол;
 - 1.5 “Дотоодын хэрэглээний шуудангийн журам батлах тухай” тус хорооны 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоол;
 - 1.6 “Дотоодын хэрэглээний холбооны сүлжээнд зохицуулалт хийх журам батлах тухай” тус хорооны 2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 65 дугаар тогтоол.
2. Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эсхүл зөвшөөрөлгүй эрхлэх үйл ажиллагаанд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийг зааж бүртгэх зохицуулалт агуулсан дараах захиргааны хэм хэмжээний актын холбогдох хэсгийг хүчингүй болгов. Үүнд:
 - 2.1 Тус хорооны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл, шаардлага”;
 - 2.2 Тус хорооны 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 23 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар баталсан “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” /телефон ярианы үйлчилгээнд/;
 - 2.3 Тус хорооны 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 88 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”;
 - 2.4 Тус хорооны 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 22 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх нөхцөл шаардлага” /Шуудангийн сүлжээ байгуулах/;
 - 2.5 Тус хорооны 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоодын болон улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”;
 - 2.6 Тус хорооны 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (интернэтийн үйлчилгээнд)”;
 - 2.7 Тус хорооны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 74 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”;
 - 2.8 Тус хорооны 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам” зэрэг болно.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Харилцаа холбооны зохицуулах хорооны баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж ирүүлсэн албан тоотоор тус хорооны 10 захиргааны хэм хэмжээний актад зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх,

хүчингүй болгохтой холбоотой харилцаа байна хэмээн дүгнэж, холбогдох арга хэмжээ авч хүчингүй болгох тухай албан бичгийг ирүүлсэн бөгөөд тус хорооны зүгээс баталсан бүх баримт бичгүүддээ үзлэг хийж, ХХЗХ-ны 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус 01 дүгээр хуралдаанаас 6 захиргааны хэм хэмжээний актыг бүхэлд нь, 8 захиргааны хэм хэмжээний актын 82 заалтыг тус тус хүчингүй болгож шийдвэрлэсэн.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит бус 01 дүгээр хуралдаанаар баталсан тогтоол, шийдвэрийг Хорооны даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/290 албан тоотор ЗГХЭГ, ХДЗХЯ, ЦХИХХЯ-нд тус тус хүргүүлэв. Эдгээр хүргүүлсэн тогтоол шийдвэрийг ХЗДХ-ийн Сайдын 2025 оны 1/1226 албан тоотор (2025-02-27) бүртгэлд хөдөлгөөн хийж, захиргааны хэм хэмжээний актаас 14 тогтоолыг бүхэлд нь болон хэсэгчлэн хүчингүй болгож хассан талаар мэдэгдэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-02-28